



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр


Дугаар A/275

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, "Хөвсгөлбаян цагаан" ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/238 дугаар захирамжаар Хөвсгөлбаян цагаан ХХК-д "Орон сууц, ногоон байгууламжийн зориулалттай"-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 7 дугаар Хиймарь-1, 114 тоотод байршилтэй 6712013191 нэгж талбарын дугаартай 4465м<sup>2</sup> газрын зориулалтыг өөрчилж, "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор, орон сууцны зориулалт"-тай болгон үлдсэн 11 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигч "Хөвсгөлбаян цагаан" ХХК (РД:4131614)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдеж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР